МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

# САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ Б.МӨНХБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

***Тайлан хянасан:*** ***Нэгжийн дарга***

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Ц.БАЯРБАТ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* 20... ... ...

***Тайлан хянасан:*** ***Нэгжийн дарга***

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА /Н.НАРАНТУЯА/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

20... ... ...

***Тайлан гаргасан:*** ***Албан хаагч***

СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ /Б.МӨНХБАЯР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

20... ... ...

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН САЛБАРЫН СУУРЬ СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ БЯМБА-ОЧИРЫН МӨНХБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Стратегийн зорилт: Салбарын статистик, суурь судалгааг боловсруулах, хөгжүүлэх, мэдээлэл, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилтийг идэвхжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх**<br>**Зорилт 10. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд салбарын үйл ажиллагааг цахимжуулах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангана.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ № 2.3.10.3 Яамны цахим хуудсыг сайжруулах, нэмэлт хөгжүүлэлт хийх, нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулах. | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хувь | Яамны www.mcud.gov.mn цахим хуудсыг 2021 онд шинэчлэн хөгжүүлсэн.<br><br>Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/168 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар | Цахим хуудасны мэдээллийн аюулгүй байдал, найдвартай байдлыг хангаж ажилласан байна.<br><br>Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралт "Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт"-ийн дагуу яамны 2023 оны ил тод байдлын тайланг нэгтгэн гаргаж 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн. ЦХИХХЯ-наас яамдын нээлттэй мэдээллийг ил тод болгож, байршуулсан тайланд үнэлгээ хийж, үнэлгээг шинэчлэгдсэн шилэн систем | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | батлагдсан “Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим хуудсыг хөтлөх журам”, хоёрдугаар хавсралтаар “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, түүнд хяналт тавих чиг үүргийн хуваарь”-ийг батлуулсан. | хангасан байна. | /shilen.gov.mn/-д ил тод нээлттэй байршуулсан. Тус нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам 96.0 хувьтай үнэлэгдсэн. Цахим хуудасны мэдээллийн аюулгүй байдал, найдвартай байдлыг хангаж, цахим хуудасны лого-г шинэчилж, стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор газар хэлтсүүдийн мэдээллийг шинэчилж, яамны албан хаагчдаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажилласан. НҮБ-ын байгууллагын “Мэдээллийн түгээмэл хүртээмжийн өдөр”-ийг тохиолдуулан “Авлигатай тэмцэх газар”, “Юнескогийн Монголын үндэсний комисс”, “Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллагатай хамтран Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Мэдээллийн хүртээмжийн тэлэлт ба төрийн үйл ажиллагаанд оролцох нь” сэдэвт хэлэлцүүлэгт 2024.09.27-ны өдөр СМСХ-ийн шинжээч Б.Мөнхбаяр, ахлах мэргэжилтэн Ц.Лхагвадорж нар оролцсон. | | |
| **Зорилт 13. Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд байршуулсан байна. Салбарын статистикийн мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжуулж өгөгдлийн сан үүсгэн, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ № 2.3.13.1 Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд шинэчлэн нийтлэх. | Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д нийтэлсэн өгөгдлийн тоо | 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд барилгын салбарын 13 нээлттэй өгөгдлийг нийтэлсэн. | Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлсэн нээлттэй өгөгдлийг тогтмол шинэчилж, хэрэглэгчдийг мэдээллээр хангасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын 5.3 дахь хэсэгт заасны дагуу "Барилга, хот байгуулалтын яамны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Барилга, хот байгуулалтын сайдаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдөр батлуулж, 2023 оны нээлттэй өгөгдлийн хэрэгжилтийн тайланг гарган Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 01/269 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn) шинэчлэн, хөгжүүлэгдсэнтэй холбогдуулан шинэ систем дээр ажиллах сургалтад 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хамрагдаж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д орсон БХБЯ-ны нээлттэй өгөгдөл, Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан "Барилга, хот байгуулалтын яамны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд орсон нээлттэй өгөгдлийг Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"- | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ын дагуу өгөгдлийг хөрвүүлэн төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд тогтоосон хугацаанд шинэчлэн нийтэлсэн. ЦХИХХЯ-наас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг үндэслэн "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-ыг шинэчлэн батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2024.08.14-ны 01/128 тоот албан бичгээр санал авахаар ирүүлсэн. "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-ыг шинэчлэн батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 2024.08.26-ны өдрийн 01/349 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-ыг шинэчлэн баталж, жагсаалтад орсон ХББОСЯ-ны нээлттэй өгөгдлийг Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу өгөгдлийг хөрвүүлэн төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд тогтоосон хугацаанд шинэчлэн нийтлэн ажиллаж байна. | | |
| 3. | Арга хэмжээ № 2.3.13.2 Барилгын нэгдсэн мэдээллийн системээр дамжуулан салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны тайлан | Хүргүүлэх мэдээллийн тоо | 2022 оны жилийн эцсийн тайлан, мэдээг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2023 | 2024 оны эхний хагас жилийн мэдээг 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар"-ын дагуу барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах, өргөх | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээг хүлээн авах ажлыг зохион байгуулж, салбарын захиргааны статистикийн мэдээлэл, орон сууцны албан ёсны статистикийн мэдээг тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх. | | оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 2/742 тоот албан бичгээр, 2023 оны эхний хагас жилийн тайлан, мэдээг 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2699 тоот албан бичгээр тус тус нэгтгэн хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br><br>Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний маягтын дагуу 2022 оны бүтэн жилийн мэдээ, тайланг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2023.01.27-ны өдрийн 3/316 тоот албан бичгээр, 2023 оны хагас жилийн мэдээ, тайланг | Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний “Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 20... оны бүтэн жилийн мэдээ”-ний маягтын дагуу 2024 оны эхний хагас жилийн мэдээ, тайланг бэлтгэн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ. | байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх, инженер геологийн судалгааны ажил гүйцэтгэх, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны мэдээ, барилгын материалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, барилгын материалын түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын мэдээ, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлгөөний мэдээ, тусгай зөвшөөрөл шинээр авсан аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн мэдээг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03/679 тоот албан бичгээр, 2024 оны эхний хагас жилийн байдлаар мэдээг нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2024.07.30-ны өдрийн 01/42 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2023 оны бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-1), ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2023 оны бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-2)-г батлагдсан маягтын дагуу нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023.06.28-ны өдрийн 3/2391 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. | | 03/271 тоот албан бичгээр, 2024 оны хагас жилийн мэдээг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 3/2043 тоот албан бичгээр тус тус нэгтгэн хүргүүлсэн. Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн 2024 оны III улирлын мэдээ (маягт А-ОС-1)-г батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргасан. Америк, Ази, Номхон далайн орнуудын үндэсний тооллого статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэг болон Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, БНСУ-ын Статистикийн газар хамтран зохион байгуулсан "Хүн амын тооллогын олон улсын 32 дугаар бага хурал"-д 2024 оны наймдугаар сарын 20-22-ны өдрүүдэд оролцсон. | | |
| 4. | Арга хэмжээ № 2.3.13.3 Салбарын албан ёсны статистик, тоон мэдээллийн жагсаалтын хүрээнд мэдээллийг цуглуулж өгөгдлийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах. | 12 бүлгийн 68 статистик, тоон мэдээлэл | Салбарын албан ёсны статистик, тоон мэдээллийн жагсаалтыг нэгтгэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулсан. | Статистик, тоон мэдээллийн жагсаалтын хүрээнд мэдээллийг цуглуулж өгөгдлийн сан үүсгэж, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангасан байна. | Статистикийн мэдээллийг бүй болгох, статистикийн мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн, тогтмол баяжилт хийх, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагч, судлаачид болон бусад хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/150 дугаар тушаалын хавсралт салбарын албан ёсны статистик, тоон өгөгдөл мэдээллийн жагсаалтын дагуу 12 бүлгийн статистик, өгөгдөл мэдээллийг шинэчлэн, баяжуулж салбарын 2023 он, 2024 оны I, II, III улирлын статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, инфографик, | 2024.01.01-2024.12.10 | ~~100~~ 90 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулга бэлтгэн ХББОСЯ-ны албан хаагчдад тархаасан. Мөн барилгын салбарын 2016-2023 оны жилийн статистикийн мэдээллийг нэгтгэн Барилга, хот байгуулалтын сайд, Барилга, хот байгуулалтын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын даргад 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр танилцуулсан. Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны мэдээ (маягт А-ОС-1)-г батлагдсан маягтын дагуу 2023 он, 2024 оны I, II, III улиралд аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан орон сууцны барилгын судалгааг нэгтгэн гаргаж, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Орон сууцжуулалтын хэлтэст хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалын дагуу Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн 2023 он, 2024 оны I, II, III улирлын судалгааг нэгтгэн гаргасан. Барилгын зарим нэр төрлийн материалын 2023 оны жилийн эцэс, 2024 оны I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI сарын импортын дүн мэдээг нэгтгэн Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын Барилгын материалын хэлтэст хүргүүлсэн. Үндэсний статистикийн хорооны аж үйлдвэрийн салбарын сар болон жилийн мэдээнд барилгын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | материалын зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг оруулж, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2023 оны жилийн эцэс, 2024 оны I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI сарын мэдээг БМХ-т хүргүүлсэн. Мөн Барилгын салбарын статистик, тоон мэдээллийг 2024 оны I, II, III улирлын байдлаар нэгтгэн гарган, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх, газрын дарга нарт танилцуулж, албан хаагчдад тархаасан. Үүнд: Барилга угсралт, их засварын ажил 2024 оны I, II, III улирлын байдлаар, салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл, барилгын салбарын ажиллах хүчний судалгаа, барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн мэдээ, салбарын мэргэшлийн зэрэгтэй инженер техникийн ажилтны тоон мэдээлэл, барилгын салбарын нэмэгдэл өртөг, барилгын салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, барилгын зарим нэр төрлийн барааны импортын мэдээ. | | |
| 5. | Арга хэмжээ № 2.3.13.4 Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн | Хүргүүлэх мэдээллийн тоо | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар "Аргачлал батлах тухай" тушаалын | Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт", "Аймаг, | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | маягт, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл маягтын дагуу мэдээллийг улирал тутам гаргаж, тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх. | | хавсралтаар баталсан "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл" маягт, "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл" маягтын дагуу мэдээллийг нэгтгэсэн. | зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн 2024 оны III, IV улирлын мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.<br><br>Тухайн нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламжийн талаар мэдээлэлтэй болж, салбарын статистикийн мэдээллийн хамралт сайжирсан байна. | нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт"-ын дагуу аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээллийг 2023 оны жилийн эцсийн байдлаар тус тус нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 3/95 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт", "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт"-ын дагуу аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээллийг 2024 оны I улирлын байдлаар нэгтгэн 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1079 тоот албан бичгээр, II улирлын байдлаар нэгтгэн 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 03/2043 тоот албан бичгээр, III улирлын байдлаар нэгтгэн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03/786 тоот албан бичгээр тус тус Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. | | |
| 6. | Арга хэмжээ № 2.3.13.5 Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбартай холбоотой судалгаа мэдээллийг нэгтгэх, өгөгдлийн сан үүсгэх, холбогдох газруудыг мэдээллээр хангах. | Хүргүүлэх мэдээллийн тоо | Статистик тоон мэдээ, мэдээллийг цуглуулж өгөгдлийн сан үүсгэн, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан. | Судалгааны нэгдсэн систем (sudalgaa.gov.mn)-д салбарын 55 судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг байршуулсан. Судалгаа мэдээллийг нэгтгэж, өгөгдлийн сан үүсгэж, холбогдох газруудыг мэдээллээр хангасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлээр "Үндэсний судалгааны нэгдсэн платформ"-ын ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх үүрэг даалгаврын дагуу 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан уулзалтад оролцож, өөрийн болон харьяа байгууллагын хариуцсан асуудлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр сүүлийн 10 жилд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайлангийн жагсаалтыг нэгтгэн гаргаж, 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03/1918 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Төрийн бүтээмжийн үндэсний хорооноос ашиглалтад оруулсан судалгааны нэгдсэн систем (sudalgaa.gov.mn)-д барилга, хот байгуулалт, газрын харилцаа, нийтийн аж ахуйн салбарын хэмжээнд хийгдсэн 60 судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг ил тод, нээлттэй байршуулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан. Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, нийтийн аж ахуйн салбартай холбоотой судалгаа мэдээллийг нэгтгэж, өгөгдлийн сан үүсгэн ажиллаж байна. | | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн бүтээмжийн үндэсний хороо, Цахим хөгжил, харилцаа, холбооны яам, Үндэсний статистикийн хорооны ажлын хэсгийн хүрээнд Мета өгөгдлийн цахим платформ байгуулах ажлын дагуу мета өгөгдлийн үзүүлэлтүүд /Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний Статистикийн Хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 206, А/184 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Салбарын бүртгэл, мэдээллийн 9 маягт, Үндэсний статистикийн хорооны дэд даргын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дугаар тушаалаар баталсан "Орон сууцны албан ёсны статистикийн 1 маягт"/-ийг цахим асуулгын дагуу мета өгөгдлийн элемент болгон ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/187 албан бичгийн дагуу Барилга, хот байгуулалтын яамны хүрээнд бүрдсэн 15-34 насны хүн амтай холбоотой судалгаа (Төрийн өмчит түрээсийн орон сууцанд түрээслэх, түрээслээд өмчлөх хэлбэрээр гэрээ хийсэн 35 хүртэлх насны иргэдийн мэдээлэл /2016 оноос 2023 оны хооронд/)-ийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Youth@mlsp.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбараас 2023 онд олгосон тусгай зөвшөөрлийн тоон мэдээллийг нэгтгэн Эдийн засаг, хөгжлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | яаманд 2024.03.29-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн.<br>Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд үндэсний түвшинд удирдлага, зохион байгуулалтаар хангаи ажиллах төрийн байгууллагуудын төлөөлөл бүхий хороог байгуулж, анхны хурлыг 2024.03.29-ны өдөр хийж, завсрын тооллогод төрийн байгууллагуудын мэдээллийн санг уялдуулах, холбох, мэдээллийн бэлэн байдал, чанарыг хангах асуудлаар хамтран ажиллаж, санал боловсруулах зорилго бүхий "Техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эрхлэх ажлын чиглэл"-ийн төсөлд 2024.04.16-ны өдрийн 01/1209 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд санал хүргүүлсэн.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалтын хэрэгжилт болон Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний "4.1-д заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах" ажлын хүрээнд тус яам болон харьяа байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх судалгааг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж, ХНХЯ-нд 2024.06.12-ны өдрийн 03/1917 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах. | Төлөвлөгөө-1 | - | Тайлангийн хэрэгжилтийн хувь | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны бүтцийн нэгжийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/03 дугаар тушаалаар байгуулж, тус ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай нийтлэг журам"-ын дагуу шинээр батлах 16 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолт, шинэчлэн батлах 72 албан тушаалын тодорхойлолтыг тус тус боловсруулж Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж батлах зөвшөөрөл авахаар 2024.10.04-ний өдрийн 01/765 тоот албан бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2024.11.06-ны өдрийн ээлжит хуралдаанаар албан тушаалын тодорхойлолт, Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2024.11.06-ны өдрийн "Зөвшөөрөл олгох тухай" 495, 496, 497 дугаар тогтоолууд албажиж, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.27-ны өдрийн Б/88, Б/89, Б/90 дугаар тушаалуудаар "Албан тушаалын тодорхойлолт"-ыг баталгаажуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2024.11.06-ны өдрийн "Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг чөлөөлж, түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай" 488 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна. | | |
| 2. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах. | Төлөвлөгөө-1 | - | Тайлангийн хэрэгжилтийн хувь | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д заасны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулагдсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1. Ёс зүйн хорооноос зохион байгуулсан "Ёс зүйн дэд хороог чадавхжуулах, мэдээллээр хангах сургалт"-д оролцсон.<br>2. Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх 2024 оны эхний хагас жилийн тайлан, ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээлэл, дэд хороо байгуулсан шийдвэрийг тус тус Ёс зүйн хороонд хүргүүлсэн.<br>3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны албан хэрэгцээнд ашиглагдах дүгнэлтийн хэвлэмэл хуудасны загварыг баталгаажуулж, 150 ширхгийг хэвлүүлж авахаар Архивын ерөнхий газарт хүсэлт хүргүүлж, хэвлүүлж авсан.<br>4. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын дагуу байгууллагынхаа дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангийн биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж, дэд хороо байгуулсан шийдвэр болон 2024 оны хагас жилийн тайлан, мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлсэн.<br>5. Ёс зүйн дэд хорооны 3 хуралдааныг зохион байгуулж, хуралдаанаас гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлсэн. | | |
| 3. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын | Судалгаа -1 Тайлан-2 | 2023 онд зөвлөлийн | Дэд зөвлөлийн | Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллах, судалгаа, мэдээллийг гаргах. | | гишүүнээр ажиллаж, судалгаа, тайланг дэд зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлсэн байна. | хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд Статистик, мэдээлэл технологийн хэлтсийн хариуцсан ажлуудыг биелэлтийг гарган, 2024 оны төлөвлөгөөнд санал хүргүүлж, салбарын зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөөний төслийг танилцуулах хуралд 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр оролцсон. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалт болон Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.5-д заасан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах" ажлыг хэрэгжүүлэх хүрээнд тус яам болон харьяа байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх судалгааг нэгтгэн гаргаж, 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03/1917 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | | |
| 2. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр | Тайлан-1 | 2023 онд зөвлөлийн гишүүнээр ажиллаж, судалгаа, тайланг дэд | Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар Барилга, хот байгуулалтын яамны орон тооны бус салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд Статистик, мэдээлэл технологийн хэлтсийн | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах, судалгаа, мэдээллийг гаргах. | | зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | ажлуудыг хэрэгжүүлсэн байна. | хариуцсан ажлуудыг биелэлтийг гарган, 2024 оны төлөвлөгөөнд санал хүргүүлж, салбарын зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөөний төслийг танилцуулах хуралд 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр оролцсон. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сургалт, хөтөлбөрт хамрагдах. | 1В улирал (хавар)-д нийт 10 кредит цаг судлах. | - | 1В улирал (хавар)-д судлах хичээлүүдийг судалсан байна. | ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуульд БНСУ-ын засгийн газрын санхүүжилттай Монгол Улсын хот байгуулалтын дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх "S-Quad" төслийн хүрээнд хэрэгжиж буй "Хот ба бүс нутгийн төлөвлөлт" магистрын хөтөлбөрийн сонгон шалгаруулалт тэнцэн, 2023-2024 оны хичээлийн жилд элсэн суралцаж байна. 2023-2024 оны хичээлийн жилийн 2 дугаар улиралд нийт 4 хичээлийн 10 кредит судлан голч үнэлгээ 3.7 байна. | 2024.01.01-2024.12.10 | 100 |
| 2. | Тайван улсын Олон улсын газрын бодлого судалгаа, сургалтын төвөөс зохион байгуулах "Газарзүйн мэдээллийн систем ба газрын менежмент-нүүрстөрөгчийн ялгарлыг тэглэх нь" сэдэвт семинарт оролцох. | Семинар-1 | - | Тайван улсын Олон улсын газрын бодлого судалгаа, сургалтын төвөөс зохион байгуулсан "Газарзүйн мэдээллийн систем ба газрын | Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн Б/38 дугаар "Гадаад томилолтын тухай" тушаалын дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын Статистик, мэдээлэл технологийн хэлтсийн шинжээч Б.Мөнхбаяр 2024 оны 04 дүгээр сарын 17-30-ны өдрүүдэд Тайван улсын Олон улсын газрын бодлого судалгаа, сургалтын төвөөс зохион байгуулсан "Газарзүйн мэдээллийн систем ба газрын менежмент-нүүрстөрөгчийн ялгарлыг тэглэх нь" сэдэвт семинарт оролцож, томилолтоор ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | менежмент-нүүрстөрөгчийн ялгарлыг тэглэх нь" сэдэвт семинарт оролцсон байна. | | | |
| 3. | Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах. | Сургалт-1 | - | Сургалтад хамрагдаж төгссөн байна. | Удирлагын академиас зохион байгуулдаг Төрийн захиргааны ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдаж, сургалтын төлөвлөгөөний дагуу 8 багц цаг буюу 8 хичээл судлаж бүрэн биелүүлсэн байхаас 6 багц цаг буюу 6 хичээлийг 2024.12.10-ны өдрийн байдлаар судлаад байна. | 2024.01.01-2024.12.10 | 100 |

98.46

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
СМСХ-ийн шинжээч
*( Албан тушаал )*

Б.Мөнхбаяр / ....Б.Мөнхбаяр.... /
*( Нэр, гарын үсэг )*

2024 ...12... 20...
*( Огноо )*